



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/89

Мандалговь

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Адаацаг сумын Ерөнхий Боловсролын Сургуулийн биеийн тамирын талбайн тохижилт”-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Б.Түвшинбаяр (АЗДТГ-ын ХЭЗХ-ийн дарга)
Гишүүд:	Э.Хөхөөхүү (Иргэний төлөөлөл)
	Д.Мөнхцоож (ХТГ-ын дарга)
	Т.Дорждамба (Дундговь-УС ОНӨАУТГ нярав)
Нарийн бичгийн дарга:	М.Бат-Эрдэнэ (ОНӨГ-ын ХАА хариуцсан мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Түвшинбаяр)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190264